



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 144/С

Алтай хот

**Худалдаа, үйлчилгээ, олон нийтийн
арга хэмжээг хориглох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", "ж" заалт, 29.2 дах хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан нутаг дэвсгэрийн хэмжээнд 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг, 06 дугаар сарын 09-ний өдөр соёл урлаг, үзвэр, спортын болон олон нийтийг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, худалдаа, үйлчилгээ эрхлэхийг тус тус хориглосугай.

2. Дээрх өдрүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах нэгдсэн болон тусгай арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир), сумдын Засаг дарга нарт, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (З.Баттулга), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар), Эрүүл мэндийн газар (Ц.Туяа), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Баттайван)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

0201000764